



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 773

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 418,411,024.00 (дөрвөн зуун арван найман сая дөрвөн зуун арван нэгэн мянга хорин дөрвөн) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Төгсдэлгэрт төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2.2. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулж, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

2.3. Холбогдох хууль, дүрэм журам, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, хандив тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг тухай бүр хуваарилж, ашиглагч байгууллагын үндсэн хөрөнгөд тусгуулах;

2.4. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэн олсон орлогын улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан төвлөрүүлэх;

2.5. Эрүүл мэндийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, эзэмшил газаргүй, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг, Оргил рашаан сувиллын хашаанд байрлалтай Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн барилгыг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлыг судалж арга хэмжээ авах;

2.6. Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн төвийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа, хариуцлагын хэлбэрийг холбогдох хууль тогтоомжид

123007293
36-r huraldaan.docx

нийцүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.7.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж, төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавих ажлыг дотоод хяналтын хорооны тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах;

2.8.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах талаар тушаалаар үүрэг болгох;

2.9.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-г даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.ТУВШИНЗАЯ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
773 дугаар тогтоолын хавсралт



Эрүүл мэндийн яаманд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн	58.0	Сангийн сайдын 2021.10.29-ний өдрийн 190 дугаар тушаал	Зардлыг зориулалтын дагуу зарцуулах
2	Түрээсийн орлого дутуу төвлөрүүлсэн	1.4	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол	Түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлэх
3	Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг хуваарилж ашиглагч байгууллагад бүртгүүлээгүй	95.7	Төсвийн тухай хууль, Нягтлах бодох бүртгэлийн тухай хууль,	Яамны болон яамны нэгдсэн санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн данс дахь хөрөнгийг тухай бүр хуваарилах
4	Үндсэн хөрөнгө дансаас хасах тогтоол, шийдвэр хэрэгжүүлээгүй	263.2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл	ТӨБЗГ-ын шийдвэрийн хэрэгжилтийг хангах
НИЙТ ДҮН:		418,411,024.00 (дөрвөн зуун арван найман сая дөрвөн зуун арван нэгэн мянга хорин дөрвөн) төгрөг		